

EJU

... ЯПОНД СУРАЛЦАХ ШАЛГАЛТЫН
ГАРЫН АВЛАГА ...



“ЯПОНД СУРАЛЦАХ ШАЛГАЛТ”

Examination for Japanese University Admission for International Students

Японд суралцах шалгалт (EJU) гэдэг нь Япон улсын их, дээд сургууль (факультет)-д элсэн суралцах хүсэлтэй гадаад иргэдийн япон хэлний мэдлэг болон үндсэн мэдлэгийг шалгадаг шалгалт юм. Япон улсын 900 гаруй их, дээд сургууль, мэргэжлийн их, дээд сургууль, коллеж, магистрын хөтөлбөр, аспирантур, технологийн коллеж, мэргэжлийн сургуулиуд тус шалгалтын дүнг гадаад оюутан элсүүлэх шалгуур үзүүлэлтдээ шаарддаг.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, гадаад хэргийн яамны дэмжлэгтэйгээр Японы оюутныг дэмжих байгууллага (JASSO) хэрэгжүүлдэг.

EJU шалгалтын онцлог



Шалгалт өгөхөд шалгуур байхгүй.
Хэн ч, хэдэн ч удаа өгч болно.



EJU-ын оноогоороо “Японд очихоос өмнө авах элсэлтийн зөвшөөрөл” авах боломжтой.



Шалгалт жилд 2 удаа зохион байгуулагддаг.
Шалгалтын дүн 2 жил хүчинтэй.



Өндөр оноо авбал тэтгэлэг авах боломжтой.

ШАЛГАЛТ АВАХ ХИЧЭЭЛҮҮД



	Хичээлүүд	Үргэлжлэх хугацаа	Оноо	Шалгалт авах хэл
1 дахь шалгалт	Япон хэл	125 минут	Уншлага, сонсгол-уншлага, сонсгол 0-400 оноо	Зөвхөн япон хэлээр
			Бичгийн шалгалт 0-50 оноо	
2 дахь шалгалт	Байгалийн ухаан Физик, хими, биологийн хичээлээс 2 хичээлийг сонгоно. Эсвэл	80 минут	0-200 оноо	Япон хэл, англи хэлний аль нэгийг сонгоно.
	Нийгмийн ухаан болон ерөнхий мэдлэг			
3 дахь шалгалт	Математик Курс-1, Курс-2-оос аль нэгийг сонгоно.	80 минут	0-200 оноо	



Шалгалт өгөгч нь элсэхийг хүссэн сургуулийнхаа элсэлтийн шалгуурт тохируулан шалгалт өгөх хичээл (1-3 хичээл) болон шалгалт өгөх хэлээ сонгоно.
Байгалийн ухаан, нийгмийн ухааны шалгалт нэгэн зэрэг явагддаг учраас аль нэгийг нь л өгөх боломжтой.

EJU шалгалт болон элсэх явц

АЛХАМ

1

Сонирхсон сургуулиа хайж олох.

АЛХАМ

2

Элсэхийг хүссэн сургуулийнхаа элсэлтийн шалгуурын талаар шаардлагатай мэдээллийг судлах.

Жишээ нь: Элсэлтийн шалгуурт тавигдах шаардлага, EJU өгөх шаардлагатай эсэх. EJU-ын ямар хичээлээр, ямар хэл дээр шалгалт өгөх, шалгалт өгөх хугацаа гэх мэт.

АЛХАМ

3

EJU шалгалтанд бүртгүүлэх → Шалгалтанд бэлдэх → Шалгалт өгөх → Дүнгээ харах.

АЛХАМ

4

Элсэхийг хүссэн сургуульдаа элсэх хүсэлт гаргах. EJU шалгалтын бүртгэлийн дугаараа илгээх.

※ Сургуулиуд таны EJU шалгалтын дүнг Японы оюутныг дэмжих байгууллагаас шууд лавладаг.

АЛХАМ

5

Элсэхийг хүссэн сургуулийнхаа шалгалтыг өгөх.

Жишээ нь: Бичиг баримтын шалгалт, ярилцлага шалгалт, суралцах чадварын шалгалт, эссе, өгүүлэл гэх мэт.

АЛХАМ

6

Элсэхийг хүссэн сургуулиас хариу хүлээн авах.



ТӨЛӨВЛӨГӨӨ



	1 дэхь удаагийн шалгалт	2 дахь удаагийн шалгалт
1-р сар		
2-р сар		
3-р сар	Шалгалтын бүртгэл	
4-р сар	↓	
5-р сар		
6-р сар	Шалгалт	
7-р сар	Шалгалтын хариу гарах	Шалгалтын бүртгэл
8-р сар		
9-р сар		
10-р сар		
11-р сар		Шалгалт
12-р сар		Шалгалтын хариу гарах



Японд: 17 хот, мужид

Гадаадад:

13 улс, бүс нутгийн 17 хотод

- Энэтхэг (Нью Дели)
- Индонези (Жакарта)
- Солонгос (Сөүл, Пусан)
- Сингапур
- Шри Ланка (Коломбо)
- Тайланд (Банкок, Чианг Май)
- Тайвань (Тайбэй)
- Филиппин (Манила)
- Вьетнам (Ханой, Хо Чи Мин)
- Хонг Конг
- Малайз (Куала Лунпур)
- Мьянмар (Янгон)
- Монгол (Улаанбаатар)



ШАЛГАЛТАНД БҮРТГҮҮЛЭХ



Шалгалтанд бүртгүүлэх арга, шалгалтын төлбөр улс бүрт өөр өөр байдаг.
Тухайн улсад шалгалт зохион байгуулдаг байгууллагаас асууж лавлаарай.



Шалгалтанд бүртгүүлэх талаар мэдээлэл авах

<https://www.jasso.go.jp/ryugaku/eju/examinee/procedure/application.html>



Лавлах хаяг

Японд шалгалт өгөх:
Японд суралцах шалгалтын
хүлээн авах төв
(+81) 0570-55-0585
eju@sdcj.co.jp

Гадаадад шалгалт өгөх:
Тухайн улсын шалгалт зохион
байгуулах байгууллага
<https://www.jasso.go.jp/ryugaku/eju/examinee/contact/index.html>





Өмнө нь зохион байгуулагдсан шалгалтын асуултууд Японы голлох номын дэлгүүрүүдийн япон хэлний тасагт зарагдаж байгаа. Гадаадад, тухайн улсын шалгалт зохион байгуулагч байгууллага, Японы оюутныг дэмжих байгууллага (JASSO)-ын гадаад дахь төлөөлөгчийн газар, Японд суралцах оюутныг мэдээллээр хангах байгууллага зэргээс лавлаж болно. Мөн өмнө нь зохион байгуулагдсан шалгалтын асуултын зарим хэсгийг EJU вэб сайтаас харах боломжтой.



Өмнөх шалгалтуудын асуултын жишээ

https://www.jasso.go.jp/ryugaku/eju/examinee/pastpaper_sample/index.html



JASSO-ын гадаад дахь төлөөлөгчийн газар (Индонези, Солонгос, Тайланд, Вьетнам, Малайз)

https://www.jasso.go.jp/ryugaku/study_j/jeic/index.html



Японд суралцах оюутныг мэдээллээр хангах байгууллага

https://www.jasso.go.jp/ryugaku/study_j/sjrf/index.html



Миний EJU-д бэлдсэн арга

Энхболд МАРАЛГУА

Элсэж орсон сургууль: Кэйогижүкү их сургууль, эдийн засгийн факультет

Улс: Монгол

EJU шалгалт өгсөн газар: Монгол

EJU шалгалт өгсөн хичээл: Япон хэл, Нийгмийн ухаан, Математик (Курс 1)



Математикийн шалгалтанд 『チャート式基礎からの数学1 + A』 номноос бэлдсэн. Шалгалтын агуулга нь Монголын математикийн хичээлийн агуулгатай ойролцоо учраас хичээл дээр үзсэн зүйлсээ бататган, дээрх номны бодлогуудыг бодож шалгалтандаа бэлдсэн. Олон янзын номноос бэлдсэнээс нэг номны бодлогуудыг олон дахин бодох нь шалгалтандаа өндөр оноо авах арга гэж бодож байна.

Нийгмийн ухааны хичээлийн шалгалтанд 『日本留学試験対策問題集 ハイレベル 総合科目』 номноос бэлдсэн. Монголын хичээлийн агуулгаас ихэнх нь өөр учраас энэ хичээлийн шалгалтанд аль болох эртнээс бэлдэж эхлэх хэрэгтэй гэж бодож байна. Дахин хэлэхэд шалгалтанд бэлдэх номныхоо дасгалуудыг дахин дахин хийж үзэж бэлдэх нь чухал шүү.



EJU шалгалтанд өндөр оноо авбал JASSO-ын тэтгэлэг (Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны гадаад оюутны сургалтын тэтгэлэг) авах эрхтэй болно.

※ Тэтгэлэг авахын тулд элсэн орсон сургуулиараа дамжуулан хүсэлт гаргах шаардлагатай.

Тэтгэлэгний хэмжээ	Авах шалгуур	Тэтгэлэг олгох хугацаа
<p>Сард 48,000 иен</p> <p>※Тухайн жилээс хамаараад өөрчлөгдөх магадлалтай.</p>	Японы их, дээд сургуулийн бакалаврын түвшин, богино хугацааны их сургууль, техникийн коллеж (3-аас дээш жил) эсвэл мэргэжлийн коллежийн оюутнаар суралцах.	6 сар, 1 жил (Элсэж орсон хугацаанаас хамаарч ялгаатай байна.)

Тэтгэлэгний хүсэлт гаргах

EJU шалгалтанд бүртгүүлэх үедээ дараах аргаар хүсэлт гаргана.

● Японд:


EJU online бүртгэл хийх үед дараах өгүүлбэрийн өмнөх дөрвөлжинд ✓ тэмдэг тавина.

留学生受入れ促進プログラム予約制度
(学習奨励費 (給付型奨学金))

奨学金予約制度に応募する

● Гадаадад:

Өргөдлийн маягтын дараах хэсгийг дугуйлна.



留学生受入れ促進プログラム予約制度
(旧学習奨励費給付予約制度)
*応募する人は右のわくに○印をつけてください。
Reservation Program for Monbukagakusho Honors Scholarship for Privately-Financed International Students
*Applicants need to mark a circle in the right box.

Тэтгэлэгт сонгох арга:

Тэтгэлэгний хүсэлт гаргасан хүмүүсээс хамгийн өндөр оноо авсан хүмүүсийг сонгодог.

Хариуг мэдэгдэх:

Тэтгэлэг авах болзол хангасан хүмүүст 1 дэхь удаагийн шалгалт бол 8-р сарын сүүлээр, 2 дахь удаагийн шалгалт бол 1-р сарын сүүлээр болзол хангасныг мэдэгдэх хуудас илгээнэ. JASSO-ын вэб сайтан дээр болзол хангасан хүмүүсийн бүртгэлийн дугаарыг зарлана.



EJU шалгалтанд өндөр оноо авснаар авах боломжтой тэтгэлэг:

https://www.jasso.go.jp/ryugaku/scholarship_j/shoreihi/yoyaku_eju/index.html





“EJU шалгалт өгөн Японд ирэхээсээ өмнө авах элсэлтийн зөвшөөрөл” гэдэг нь та өөрийн амьдарч байгаа улс, бүс нутагтаа EJU шалгалт өгөн, тухайн шалгалтын хариу болон ахлах сургуулийн дүнг илгээн, Японд очилгүйгээр тэнцэх, үгүйгээ шийдвэрлүүлэх арга юм. Ойролцоогоор Япон улсын 200 гаруй их, дээд сургууль тухайн зөвшөөрлийг нэвтрүүлсэн байна.

※ Зарим их сургууль EJU шалгалтын дүнгээс гадна танай улс, бүс нутагт ярилцлагын шалгалт эсвэл бичгийн шалгалт зохион байгуулах тохиолдол байдаг.

EJU шалгалт өгөн өндөр оноо авч чадвал их сургуулиа төгстлөө

JASSO-ын тэтгэлэг авах эрхтэй болох боломжтой.



“EJU шалгалт өгөн Японд ирэхээсээ өмнө авах элсэлтийн зөвшөөрөл” олгодог их, дээд сургуулиуд

<https://www.jasso.go.jp/ryugaku/eju/examinee/prearrival/index.html>



“EJU шалгалт өгөн Японд ирэхээсээ өмнө авах элсэлтийн зөвшөөрөл” авч чадсаны сайн тал

Хан ОЖИН

Суралцаж байгаа их сургууль: Доошиша их сургууль, Соёл мэдээллийн салбар

Улс: Солонгос

EJU шалгалт өгсөн газар: Солонгос (Сөүл)

EJU шалгалт өгсөн хичээлүүд: Япон хэл, Нийгмийн ухаан, Математик



Эх орондоо EJU шалгалт өгөөд, их сургуульд тэнцэх, үгүйгээ мэдэх боломжтой “EJU шалгалт өгөн Японд ирэхээсээ өмнө авах элсэлтийн зөвшөөрөл”-ийн ачаар маш богино хугацаанд бэлтгэлээ хийн их сургуульд орж чадсан. Гадаадад сурах бэлтгэлд мэдээж шалгалтандаа бэлдэхээс гадна тэнцсэний дараа бичиг баримт бүрдүүлэх гээд ажил их бий. Хэрвээ Японд очсоныхоо дараа эдгээр элсэх бэлтгэлийг хийсэн бол таних хүнгүй гадаад улсад ганцаараа учраас сэтгэл санааны хувьд ч, санхүүгийн хувьд ч хэцүү байх байсан гэж бодож байна. “EJU шалгалт өгөн Японд

ирэхээсээ өмнө авах элсэлтийн зөвшөөрөл” авснаар иймэрхүү хэцүү зүйлийг үзэж туулахгүйгээр, миний амьдралын нэгэн зорилго болох Японд суралцах хүслээ биелүүлэхээр зорин улам их хичээн хичээлээ давтаж чадсан. Мөн Японд ирээд шалгалтанд бэлдсэн бол Японд амьдрах талаар мэдэхгүй зүйл их байсан болохоор одоогийнх шиг ийм сүрхий гадаад оюутан болж чадахгүй байсан байх гэж бодож байна. “EJU шалгалт өгөн Японд ирэхээсээ өмнө авах элсэлтийн зөвшөөрөл” авч чадсаны ачаар их сургуулийн амьдрал маань илүү хөгжилтэй, сайхан байна.



A1. Японы их, дээд сургууль, коллежид элсэх хүсэлтэй хүн заавал EJU шалгалт өгөх шаардлагатай юу?

X. EJU шалгалт Японы ихэнх их сургуулиуд элсэлтэндээ шаарддаг боловч, EJU өгөхгүйгээр элсэж орох боломжтой их, дээд сургуулиуд ч байдаг. Тухайн сургуульд элсэхэд EJU шалгалт өгөх шаардлагатай эсэхийг элсэж орох хүсэлтэй сургуулийнхаа элсэлтийн журмаас хараарай.



EJU-г элсэлтэндээ шаарддаг сургуулиудын жагсаалт

<https://www.jasso.go.jp/ryugaku/eju/examinee/use/index.html>



A2. Нийгмийн ухааны шалгалт гэж ямар хичээлийн шалгалт байдаг вэ?

X. Нийгмийн ухааны шалгалт нь EJU-ын бие даасан шалгалт бөгөөд Японы ахлах сургуульд үздэг “Иргэн” (Улс төр, эдийн засаг голлон), “Газарзүй”, “Түүх” гэсэн хичээлүүдийн нэгдсэн агуулгаар авдаг.



Хичээлийн хөтөлбөр (Шалгалтын агуулгын хүрээнд)

<https://www.jasso.go.jp/ryugaku/eju/examinee/syllabus/index.html>



A3. JLPT шалгалтын N1, N2-т тэнцсэн байсан ч EJU шалгалт өгөх шаардлагатай юу?

X. JLPT-д тэнцсэн байсан ч EJU шалгалтын оноог шаарддаг сургуульд элсэх тохиолдолд EJU шалгалт өгөх шаардлагатай. Гэхдээ EJU шалгалт зохион байгуулагддаггүй улс, бүс нутагт амьдардаг хүний хувьд JLPT шалгалтын оноог шаардах тохиолдол байдаг учраас, урьдчилаад элсэхийг хүсч буй сургуулиасаа энэ талаар лавлаж асуугаарай.

A4. Хөгжлийн бэрхшээлтэй хүн шалгалт өгөх боломжтой юу?

X. Шалгалт өгөх боломжтой. Тусгай арга хэмжээ авах шаардлагатай бол шалгалт өгөхөөс өмнө шалгалт зохион байгуулж байгаа байгууллагатай зөвлөлдөж, тусгай шалгалт өгөх талаарх бичиг баримтыг бүрдүүлэх талаар зааварчилгаа авах ёстой. Тусгай арга хэмжээний өргөдөл гаргахад эмчийн магадлагаа зэрэг тусгай арга хэмжээ авах шаардлагатай илтгэх бичиг баримтуудыг бүрдүүлэх хэрэгтэй.

